

Б.Мижид, АИХ-ын депутат

депутат асан Тогоочийн Шир-  
мэн нарыг шагналаа.

*Үндэсний шуудан*

# НҮБ долдугаар сарын 1-ний

## асуудлыг хэлэлцэнэ

2010.01.14 №010/224

**Г.САНЧИР**

Монгол Улсын Засгийн газар хүний эрхийг хангах, хамгаалах талаар олон улсын болон иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хэрхэн хэрэгжүүлж байгааг 2010 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүд дүгнэн хэлэлцэх гэж байна. Уг дүгнэлт хэлэлцүүлэгт Монгол Улсын Засгийн газар үндэсний тайлан бэлтгэн оролцохоос гадна Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, төрийн бус байгууллагууд тайлан илтгэл бэлтгэн оруулах боломжтой гэнэ. Хүний эрх хөгжил төв болон "Глоб интернэшнл" ТББ хамтран Хүний эрх хөгжлийн төлөөх Азийн форум хэмээх бүсийн хүний эрхийн байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулсан "Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт хэлэлцүү-

лэгт төрийн бус байгууллагууд бэлтгэх нь" сургалт, зөвлөгөөнд хүний эрхийн янз бүрийн чиглэлээр ажилладаг 40 гаруй төрийн бус байгууллага оролцсон байна.

Зөвлөлгөөнөөс Хүний эрхийн ээлжит үзлэгт бэлтгэх Монголын төрийн бус байгууллагуудын форумын байгуулж, дараахь асуудлаар хүний эрхийн илтгэл бэлтгэн Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт илгээхээр тогтлоо. Үүнд, 2008 оны долдугаар сарын 1-ний үйл явдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн талаархи илтгэл, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт багтжээ. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт бэлтгэх төрийн бус байгууллагуудын форум нь нээлттэй ажиллах бөгөөд хүний эрхийн асуудалд санаа зовнин ажилладаг төрийн бус байгууллага, иргэдийг идэвхтэй оролцож хамтран ажиллахыг урьж байна.

**ҮНДЭСНИЙ**

ҮНДЭСНИЙ ӨДӨР ТУТМЫН СОНИН

**ШУУДАН**

сайн  
хэди  
анха  
ламх  
зайл  
болл  
рийн  
гуул  
дөө х  
Хүнд  
чихээ  
нутги  
түрүү  
нэрвэ  
даа т  
хэвлэ  
гэсэн.  
олон  
Улаан  
лаж а

**Г.С**  
**Монгол**  
**Ерөнх**  
**Ш.ГУ**  
**ярилц**

-Хар  
риу  
нуу